


Хувьцааны мэдээлэл

Ханш /2025.01.27/	24000₮
Target price	24571.42₮
Тикер	MSE:TDB
52 долоо хоног	23520-29960₮
Зах зээлийн үнэлгээ	1.214 их наяд ₮
Нийт хувьцааны тоо	506,00,927
EPS	5931
P/B	0.82
P/E	4.05

Хувьцаа эзэмшигчдийн бүтэц



Ханшийн хөдөлгөөн /2024.01-2025.01/



“Худалдаа Хөгжлийн Банк” ХК

BUY Target price/2025.12.31/: 24571.42₮

Компанийн тухай

“Худалдаа Хөгжлийн Банк” нь 1990 онд Монгол Улсын анхны арилжааны банк болгон байгуулагдсан. Тус банк нь Монгол Улсын банк, санхүүгийн салбарт тэргүүлэгчдийн нэг бөгөөд олон улсын жишигт нийцсэн бүтээгдэхүүн, үйлчилгээг санал болгон 90 орчим салбартай үйл ажиллагаа явуулж байна.

2024 оны онцлох үйл явдлууд:

- Худалдаа Хөгжлийн Банк АНУ-ын The Bank of New York Mellon-тай хамтын ажиллагааг эхлүүлсэн
- ХХБ Монгол улсаас анх удаа олон улсын зах зээлд Ногоон болон Нийгмийн бонд гаргасан.
- Аlpaу төлбөр тооцоо хийдэг болсон
- ХХБ нь “Зөгийн үүр” хөтөлбөрийн хүрээнд 2023,2024 онуудад ажилтнуудын бүтээмжийн цалинг 25% нэмсэн.

Системийн 5 банкны төлөв байдал

“Худалдаа Хөгжлийн Банк” нийт активын хэмжээ 2024 оны жилийн эцсийн байдлаар өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2.8 наяд төгрөгөөр буюу 23.4 хувиар өсөж 15 их наяд төгрөгт хүрсэн байна. Худалдаа Хөгжлийн банк нийт активын хэмжээгээр системийн 5 банктай харьцуулахад 3-т жагсаж байгаа бөгөөд нийт банкны салбарын 21% дангаараа эзэлж байна.


Банкнүүдэн хувьцааны үнэ 2025 оны 1 сарын 29-ий байдлаар 24000 төгрөг байгаа бөгөөд анх гаргасан IPO үнээс (33000) -27 хувийн бууралттай байна.

	ROA	ROE	P/B	Нийт хөрөнгө*	Цэвэр ашиг*
Khan	3.2%	26.3%	0.9	20,302.7	638.5
GLMT	2.6%	32.1%	0.8	15,410.2	407.3
TDB	2.2%	20.8%	0.82	15,016.0	300.1
SBM	1.9%	17.8%	0.6	6,218.5	108.0
XAC	2.7%	25.6%	1.2	6,317.7	170.8
Дундаж	2.4%	24.3%	0.9	12,653.0	324.94


*тэрбум ₮

САНХҮҮГИЙН ШИНЖИЛГЭЭ

ROA, ROE /хувиар/



Ашгийн үзүүлэлтүүд /тэрбум ₮, хувиар/



	2020	2021	2022	2023	2024
Зээл хадгаламжийн харьцаа	82.3%	81.4%	68.6%	58%	62.9%
Чанаргүй зээлийн хувь	13.9%	18.7%	18.3%	11.4%	4.2%

АШИГТ АЖИЛЛАГААНЫ ҮЗҮҮЛЭЛТҮҮД /ROA,ROE/

Банкны өөрийн хөрөнгө 2024 оны байдлаар 1.4 их наяд төгрөг байгаа ба өмнөх оны мөн үеэс 4.9 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Банкны өөрийн хөрөнгийн өгөөж 2020 онтой харьцуулахад 20.4% өссөн нь Худалдалдаа Хөгжлийн Банк нь өөрийн хөрөнгө ашиглалт сайжирч, бизнесийн стратеги, урт хугацааны төлөвлөлт амжилттай байгааг харуулж байна. ХХБ нийт активын өгөөж 2024 оны эцсийн байдлаар 2.2%-тай гарчээ.

Хүүгийн орлогын маржин

2024 оны эцсийн байдлаар Худалдаа Хөгжлийн Банкны хүүгийн орлого өмнөх онтой харьцуулахад 39.2%-аар өсөж 1 их наяд төгрөгт хүрсэн бол цэвэр хүүгийн маржин өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0.7 хувиар өсөж 3.4%-д хүрсэн байна.

Цэвэр ашгийн маржин

Худалдаа Хөгжлийн Банкны цэвэр ашиг өмнөх оны жилийн эцэстэй харьцуулахад 98%-н өсөлт үзүүлсэн ба 2024 онд цэвэр ашиг 300 тэрбум төгрөгт хүрсэн үзүүлэлттэй гарсан байна. Цэвэр ашгийн маржин 2023 онд өмнөх оны үзүүлэлтээс 9%-н буурсан үзүүлэлттэй гарсан бол 2024 оны жилийн эцсийн байдлаар 28.2% болж 8.4% өссөн үзүүлэлттэй байна.

Үндсэн үйл ажиллагааны үзүүлэлтүүд

Худалдаа Хөгжлийн банкны нийт цэвэр зээл 6 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 23 хувиар өссөн ба нийт хөрөнгийн 40.4 хувийг эзэлж байна. Худалдаа Хөгжлийн Банкны (Харилцах\Хадгаламжийн) хувьд өмнөх оны мөн үеэс 13 хувиар өсөж 9.6 их наяд төгрөг хүрсэн 2024 оны жилийн эцсээр гарсан байна. Чанаргүй зээлийн хувьд 2024 оны байдлаар 4.2 хувь хүрсэн ба өмнөх оны мөн үеэс 7.2 хувиар буурсан нь банкны зээлийн эрсдэлийн удирдлага буурсныг харуулж байна.

Зээл хадгаламжийн харьцаа

Олон улсын түвшинд зээл хадгаламжийн харьцаа 70-90% зохистой хэвийн хэмээн үздэг. Худалдаа Хөгжлийн Банкны Зээл хадгаламжийн харьцаа нь 62.9% буюу харьцангуй бага түвшинд байна.

ДҮГНЭЛТ

2024 оны эцсийн байдлаар тус компанийн P/B харьцаа 0.82, P/E харьцаа 4.05 байна. Тус үзүүлэлт бага байгаа буюу компанийн хувьцаа зах зээл дээр бодит үнэ цэнээс бага үнэлэгдэж, ашигтай ажиллаж байгаа ч ханш хямд байгааг илтгэнэ. 2024 онд Худалдаа Хөгжлийн Банк ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 7 сарын 16-ий өдөр 2023 оны цэвэр ашгаас нэгж хувьцаанд 1033 төгрөгийн ногдол ашиг хуваарилсан байна.